



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 09 өдөр

Дугаар А/138

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” –ын 4.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Зөрүүлэг багийн Нарийн, Онгоцот малын тарилгын хашаа барих ажил, Хүйтэн булагийн Мухар хустын булагийг хаших, 4 дүгээр багийн худаг засварлах, багаж техник хэрэгсэл, материал худалдан авсан ажлуудыг хүлээн авах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)  
Гишүүд: Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)  
Г.Бямбагарав 5 дугаар багийн Засаг дарга  
Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)  
Р.Даваасүрэн (Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасны дагуу хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсэг (Н.Орхонтуул)-д даалгасугай.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн дээрх 4 (дөрвөн) ажлыг Засаг даргын Тамгын газрын өмчийн бүртгэлд бүртгэж, ашиглалт хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам), Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Э.Дашдулам) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

622201377